Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А / 95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Хүний эрхийн бодлогын газрын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтэс
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтсийн хяналтын прокурор	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, нэгж прокурорын газрыг мэргэжлийн удирдлагаар хангахад дэмжлэг үзүүлэх.

Албан тушаалын зорилт:

1.Гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
2.Хэлтсийн чиг үүрэгт хамаарах ажлыг хариуцан хийж гүйцэтгэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг хангах.	Дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг хангасан байна.	Т, Г
	1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд санал өгөх, хариуцсан ажлыг хийж гүйцэтгэх.	Төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэсэн байна.	Г
	1.3.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, заавар, мэдээлэл, санал, албан бичигт гаргах санал, тайлбарын төсөл боловсруулах.	Санал, тайлбарын төслийг боловсруулсан байна.	Г
	1.4.Нэгж прокурорын газарт өгөх хугацаатай үүрэг даалгаврын төслийг боловсруулж, танилцуулах.	Үүрэг даалгавар хуульд нийцсэн, чиг үүрэгт хамаарахуйц байна.	Г
	1.5.Газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г
	1.6.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г
	Гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр		
	1.7.Гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.	Ажил, арга хэмжээ хамтран хэрэгжүүлсэн байна.	Г
	1.8.Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, дэд зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөнд санал өгөх, тусгагдсан ажлын хэрэгжилтийг зохион байгуулах.	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Г

	1.9.Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах.	Төлөөллийг хэрэгжүүлсэн байна.	Г
	1.10.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох судалгааг дангаар болон бусад байгууллагатай хамтран хийх.	Судалгаа хийж, үр дүнг танилцуулсан байна.	Г
	1.11.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон хэрэгт бичсэн прокурорын дүгнэлтийг нэгтгэн дүгнэж, танилцуулах	Дүгнэлтийг нэгтгэж, үр дүнг танилцуулсан байна.	Г
	1.12.Гэмт хэрэг, зөрчил, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгааг хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	1.13.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дотоодын хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, олон улсын байгууллагын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах.	Тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байна.	Г
	1.14.Холбогдох зохион байгуулалтын бүтцийн нэгж, нэгж прокурорын газруудаас эрүү шүүлт тулгах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг авч, нэгтгэн, танилцуулах.	Мэдээ, мэдээллийг нэгтгэн, дүгнэлт хийсэн байна.	Г
	1.15.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зааврыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	Зааврын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр		
	1.16.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд мөрдөх журмыг хэрэгжүүлэх, хяналт тавих	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	1.17.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр нийтэд мэдээлэгдсэн хэрэг, зөрчлийн явц, шийдвэрлэлтийн талаар нийтэд мэдээлэх, ярилцлага өгөх, хэвлэлийн хурал зохион байгуулах.	Олон нийтийн мэдээлэл авах эрх хангагдсан байна.	Г
	1.18.Прокурорын байгууллага, прокурор, ажилтны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан сөрөг мэдээлэлд авах хариу арга хэмжээний санал танилцуулах, шийдвэрлүүлэх.	Олон нийтийг мэдээллээр хангасан байна.	Г

	1.19.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчээс ирүүлсэн мэдээлэл авах тухай санал, хүсэлтийг судалж, танилцуулах.	Санал, хүсэлтийг танилцуулж, шийдвэрлэсэн байна.	Г
	1.20.Прокурорын байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээний санал танилцуулах.	Санал гаргаж, танилцуулсан байна.	Г
	1.21.Олон нийттэй харилцах ажлын үр нөлөөг судалж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг танилцуулах.	Ажил, арга хэмжээний саналыг танилцуулсан байна.	Г
	1.22.Байгууллагын үйл ажиллагаа болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэж, нийтэд түгээх ажлыг гүйцэтгэх.	Мэдээ, мэдээллийг нийтэд түгээсэн байна.	Г
	1.23.Прокурорын байгууллагын цахим хуудсын хэвийн үйл ажиллагааг хангах.	Цахим хуудаст баяжилт, шинэчлэл хийгдсэн байна.	Г
	1.24.Хариуцсан ажлын чиглэлээр иргэн, хуулийн этгээд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн болон Олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтарч хийж буй ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх.	Хамтын ажиллагаа үр дүнд хүрсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Газрын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна.	Г
	2.2.Хэлтсийн хэмжээнд хяналтын ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлөх.	Бүртгэл, судалгааг хөтөлсөн байна.	Г
	2.3.Газар, хэлтсийн даргаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангаж, үр дүнг танилцуулах.	Өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлж, танилцуулсан байна.	Г
	2.4.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г
	2.5.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г

	2.6.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аян, нөлөөллийн арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах.	Ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан байна.	Г, Х
	2.7.Прокурорын байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг сурталчлах, мэдээ, мэдээлэл бэлтгэх, танилцуулах, нийтэд түгээх ажлыг зохион байгуулах.	Мэдээ, мэдээлэл нь хүртээмжтэй байх, -Мэдээллийг түгээсэн байна.	Г, Х
	2.8.Прокурорын байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээн дэх албан ёсны хаягт баяжилт, хөдөлгөөнийг хийх, хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээ, мэдээллийг шинэчлэх ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Хэвийн үйл ажиллагаа хангагдаж, үнэн зөв бодит мэдээллийг түгээсэн байна.	Г,Х
	2.9.Зохион байгуулалтын бүтцийн нэгж болон нэгжийн прокурорын газраас ирүүлсэн мэдээ, мэдээллийн үнэн зөвийг нягталж, засварлах, байгууллагын болон нэгж прокурорын газрын цахим хуудаст байршуулах ажлыг зохион байгуулах.	Мэдээ, мэдээллийг хянаж, нийтэлсэн байна.	Г, Х
	2.10.Улсын ерөнхий прокурорын газраас зохион байгуулж буй нэгдсэн арга хэмжээнд оролцож, мэдээ, мэдээлэл бэлтгэх, дамжуулах, гэрэл зураг, дуу, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулах ажлыг зохион байгуулах.	Арга хэмжээнд оролцож мэдээ, мэдээллийг түгээж, үйл ажиллагааг баримтжуулсан байна.	Г, Х
	2.11.Прокурорын байгууллагын цахим бүртгэлийн системд хийсэн ажил, арга хэмжээг бүртгэх, мэдээ үнэн зөв гарах нөхцөлийг бүрдүүлэх.	Бүртгэл, үнэн зөв хөтлөгдсөн байна.	Г
	2.12.Хийсэн ажлын мэдээ, тайланг боловсруулж танилцуулах.	Мэдээг үнэн, зөв гаргасан, тайланг шаардлагын дагуу бичсэн байна.	Г
	2.13.Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулах ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Мэдээлэл байршсан байна.	Г
	2.14.Мэдээ, мэдээлэл, гэрэл зураг, дуу, дуу-дүрсний бичлэгийг бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар баримтжуулж, архивын нэгж болгох ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г, Х

<table>
<tr><th colspan="3">III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</th></tr>
<tr><td>Боловсрол</td><td colspan="2">Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй</td></tr>
<tr><td>Мэргэжил</td><td colspan="2">Эрх зүй (0421)</td></tr>
<tr><td>Мэргэшил</td><td colspan="2">-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх
-хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх</td></tr>
<tr><td>Туршлага</td><td colspan="2">Прокуророор 5-аас доошгүй жил, үүнээс Нийслэлийн прокурорын газрын хяналт, ахлах прокурор, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, ахлах прокуророор 3-аас доошгүй жил ажилласан байх</td></tr>
<tr><td rowspan="4">Ур чадвар</td><td>Дүн шинжилгээ хийх</td><td>-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах;
-шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх;
-судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.</td></tr>
<tr><td>Асуудал шийдвэрлэх</td><td>-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох;
-шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох;
-хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах;
-гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.</td></tr>
<tr><td>Багаар ажиллах</td><td>-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох;
-хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх;
-мэдээллийг нээлттэй хуваалцах;
-бусдын санал бодлыг хүндэтгэх.</td></tr>
<tr><td>Бусад</td><td>-баримт бичиг боловсруулах;
-хууль хэрэглэх;
-ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах;
-албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.</td></tr>
<tr><th colspan="3">IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ</th></tr>
<tr><td colspan="3"><u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>
1.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хүний эрхийн бодлогын газрын дарга
2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтсийн дарга, ахлах прокурор</td></tr>
<tr><td colspan="2"><u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>

1. Газар, хэлтсийн туслах ажилтан
2. Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын хүний эрх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажил хариуцсан прокурор
3. Сум дундын прокурорын газрын хяналтын прокурор

Нийт: 3</td><td><u>Бусад харилцах субъект:</u>

1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан
2.Шүүх
3.Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага
4.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага
5.Шийдвэр гүйцэтгэх байгууллага
6.Бусад төрийн байгууллага
7.Иргэн, хуулийн этгээд</td></tr>
</table>

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2
Албан тушаалын тодорхойлолт баталсан:	
Байгууллагын нэр: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Дугаар: А/95 УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ: Б.ЖАРГАЛСАЙХАН 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр	